

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУДАД
ЗОРИУЛСАН “ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ИМПОРТ, ЭКСПОРТЫН БҮРТГЭЛИЙН
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТАВИГДАХ ШААРДЛАГА”-ЫН ТАЛААРХ ЦАХИМ ГАРЫН
АВЛАГЫН АЖЛЫН ТАЙЛАН**

Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар байгуулагдаж, эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын чиг үүргийг нэг дор төвлөрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн. Мөн 2023 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой бусад хууль, журамд нэмэлт өөрчлөлт орох, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагуудад хууль эрх зүй, түүнтэй холбоотой журам, бүрдүүлэх баримт бичиг, ажлын байранд тавигдах шаардлагын талаар мэдээллээр хангах хэрэгцээ үүссэн.

Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, мэдээллийг хурдан шуурхай хүргэх, тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллагуудад хууль эрх зүй, холбогдох журам, тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, импорт, экспортын бүртгэл, эм, оношлуурын бүртгэлийн талаарх мэдээлэл олж авах, мэдээллийг үйл ажиллагаандаа хэрэглэх, материал бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангахад ашиглаж байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг хэрхэн ашиглах, хадгалах, илгээх болон хүлээн авахад энэхүү цахим гарын авлага чухал ач холбогдолтой юм.

ЦАХИМ ГАРЫН АВЛАГА 2 ХЭСЭГТ ХУВААГДАНА:

1. Тусгай зөвшөөрөл
2. Импорт, экспортын бүртгэл /лиценз/

Цахим гарын авлагын нэгдсэн мэдээлэлд:

1. **Хууль, эрх зүй**
 - 1.1 Зөвшөөрлийн тухай хууль
 - 1.2 Эрүүл мэндийн тухай хууль
 - 1.3 Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
2. **Тушаал, журам**
 - 2.1 ЭМС-ын 2013 оны А/145-р тушаалаар батлагдсан журам
 - 2.2 ЭМС-ын 2021 оны А/400-р тушаалаар батлагдсан журам
 - 2.3 ЭМС-ын 2015 оны А/264-р тушаалаар батлагдсан журам
 - 2.4 ЭЭХХЗГ-ын даргын 2021 оны А/148-р тушаалаар батлагдсан журам
 - 2.5 ЭЭХХЗГ-ын даргын 2023 оны А/48-р тушаалаар батлагдсан импорт, экспортын бүртгэл олгох журам, үйл ажиллагааны стандарт ажиллагааны заавар
 - 2.6 ЭМС-ын 2016 оны А/232 тушаалаар батлагдсан журам
3. **Төсөл бичих заавар**
 - 3.1 ЭМС-ын 2023 оны А/100 тушаал “ Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичигт тавигдах шаардлага”
4. **Бүрдүүлэх материалын жагсаалт**
 - 4.1 Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт бүртгэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

5. Үйл ажиллагааны зураглал

5.1 Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, хаягийн өөрчлөлт бүртгэх үйл ажиллагааны ажлын зураглал

6. Программ болон цахим сайтыг хэрэглэх заавар


6.1 Эмийн бүртгэл, тусгай зөвшөөрөл, импортын лицензийн нэгдсэн мэдээлэлийг агуулсан лэйсмед программыг хэрхэн хэрэглэх тухай заавар

6.2 И-Монгол академийн төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын систем и-монголиа хэрэглэх заавар


6.3 Эрүүл мэндийн салбарын тусгай зөвшөөрөл олголтын tzmoh.gov.mn цахим сайтыг хэрэглэх заавар

Үр дүн:


1. Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллагад одоогийн мөрдөгдөж буй хууль эрхзүй, журам, стандарт, ажлын байранд тавигдах шаардлага, бүрдүүлэх бичиг баримт, тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хэрхэн цахимаар мэдээлэх, шийдвэрлэлтийн явц, үе шатыг цахимаар хянах-tz.moh.mn хэрхэн ашиглах заавар зэрэг холбогдох мэдээллийг оруулсан.



2. Импорт, экспортын бүртгэлийн талаарх шинэчлэгдсэн хууль эрхзүй, холбогдох журам, импортын бүртгэл мэдүүлэгч байгууллагад бүрдүүлэх баримт бичгийн загвар, цахимаар хүсэлт илгээх, үр дүнгээ авах



Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын бүртгэл хүсэгч байгууллагын ирүүлэх материал, барааны мэдээллийг лайсмед программаар хэрхэн илгээх, хэрэглэх заавар, боловсруулалт, үр дүнгийн мэдээлэл харах, хэвлэх зэрэг нэгдсэн мэдээллийг тусгасан нийт 30 хуудас бүхий цахим гарын авлагыг боловсруулсан.



Мөн цахимаар мэдээлэл авах боломжгүй иргэд, аж ахуйн нэгжид зориулан цаасан гарын авлагыг боловсруулан хэвлэн, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаа.

ХЯНАСАН:

Л.ЗЭНДМАА / ЛЗЗГ-ЫН ДАРГА/

О.ОДОНЧИМЭГ /ЛЗЗГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН/

ТАЙЛАН БИЧСЭН:

А.НОМИНДАРЬ /ЛЗЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН/